



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/458

Ховд

Дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Чандмань хангай" ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Жишиг гудамж /Жаргалант сум/-ны IV-р багцын ажилд ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй, нэмэлтээр хийгдсэн ажлыг нягтлан шалгаж нэмэлт гэрээ байгуулан санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Түмэндэмбэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Н.Ганзориг

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Туулайтулга

- Жаргалант сумын Засаг даргын орлогч

Б.Оюунгэрэл


- "Чандмань хангай" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн
дарга Д.Тогтохбаяр

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын Барилга, хот байгуулалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Тус ажлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

Заг А/458 Кн